



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2025 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/534

Улаанбаатар хот

**Өрийн хэрэгсэл бүртгэлээс хасах тухай**

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.9, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 23 дугаар зүйлийн 23.1, 23.11.5 дахь заалтууд, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01/1380 болон 01/1381 тоот албан бичгүүдийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын хөрөнгийн биржээр арилжигдсан "Шунхлай" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хөтөлбөрийн хүрээнд гаргасан нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 800,000 (найман зуун мянга) ширхэг, SHHK (3051 ба 3053) кодтой "Шунхлай бонд"-ийн үндсэн болон хүүгийн төлбөр бүрэн төлөгдөж дууссан тул "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн үнэт цаасны бүртгэлээс хассугай.
2. Өрийн хэрэгслийг бүртгэлээс хассан тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороонд, холбогдох мэдэгдлийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" хязгаарлагдмал хариуцлагатай компанид тус тус хүргүүлэхийг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т үүрэг болгосугай.
3. Өрийн хэрэгслийг бүртгэлээс хассан тухай мэдээллийг олон нийтэд хүргэхийг Бизнес хөгжлийн газар (Т.Хаш-Эрдэнэ)-т, цахим хуудас болон арилжааны системд холбогдох өөрчлөлт хийхийг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т тус тус даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын мэргэжилтэн Ч.Эрдэнэболорт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

  
Д.МӨНХБАТ  


15250311'9